

## ДЭЛХИЙ ЕРТӨНЦ ИРЭХ 10 ЖИЛД

*Д.Золбоо\**

Хүн төрөлхтний түүхэнд ирээдүй цагийн өнгө төрхийг тааварлан мэдэх, тодорхойлох хүсэл эрмэлзлэл нэлээд эртнээс улбаатай. Эрт үед энэ зорилгоор шашин шүтлэг, мэргэ төлгийн болоод зан үйл, бэлгэ дэмбэрэлийн холбогдолтой арга зонхилдог байсан бол өнөө үед орчин цагийн техник, технологийн ололт амжилт дээр тулгуурласан судалгаа, эрдэм шинжилгээний үндэслэлтэй таамаглал боловсруулан бэлтгэх болсныг бид бүхэн мэдэх билээ.

Энэ удаа орчин цагийн улс төрийн харилцаа, гадаад бодлогын үүднээс боловсруулсан нэгэн таамаглалыг та бүхэнтэй хуваалцах гэсэн юм. Өнөөгийн дэлхий дахины улс төрийн хөгжлийн чиг хандлага, бодлогыг цөөхөн хэдэн их гүрэн ерөнхийд нь тодорхойлон авч явдаг болсон нь маргашгүй үнэн. Тэгвэл эдгээр гүрний нэг болох ИБУИНВУ буюу Британий гадаад бодлого судлаачдын боловсруулсан таамаглалтай танилшвал сонирхолтой байх болов уу. Энэхүү гадаад бодлогыг хариуцан тодорхойлон, авч явдаг Британий Гадаад болон Хамтын нөхөрлөлийн хэргийн яамны албан ёсны веб хуудсанд байрлуулсан “Дэлхий ертөнц ирэх 10 жилд” гэсэн сонирхолтой судалгааны нийтлэл тавигджээ.

Британи бол дэлхий дахины түүхтэй салшгүй холбоотой арвин, баялаг түүхтэй улс гүрний нэг билээ. Өнгөрсөн XX зууны 2 том дайнд голлох үүрэг гүйцэтгэж байсан их гүрний нэг энэ улс өнөөдөр эдийн засгийн хүчин чадлаараа дэлхийд 4-д, гадаад улсад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ АНУ-ын дараа 2-т ордог, олон улсын байгууллагын үйл ажиллагаан дахь үүрэг, оролцоогоороо Францын дараа орохуйц хэмжээнд идэвхтэй оролцдог, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн энэ орны гадаад бодлого нь дэлхий дахины улс төр, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлогч томоохон хүчин зүйлийн нэг гэдгийг хүлээн зөвшөөрөх биз.

Хүйтэн дайнаас хойш 15 жилд Британий гадаад бодлого нь Европын төвлөрлийг буй болгоход чиглэгдэж байсан гэж үзэж болох ажээ. Үүнд Германы нэгдэл болон ЗХУ, Югославын задрал, Төв болон Өрнөд Европын аюулгүй байдал хийгээд ардчиллын сэргээн босголт, Европын холбоо болон НАТО-гийн гишүүнчлэл, түүний зохион байгуулалтын асуудал, мөн Транс Атлант (Америк, Европын) харилцаа холбооны шинэ эхлэлийг тавьсан зэргийг нэрлэж болох ажээ. Эдгээр нь бүгд маш амжилттай хэрэгжиж байсныг тэмдэглэх хэрэгтэй болов уу.

Хүйтэн дайны төгсгөл нь хүн төрөлхтний ихэнх хэсэгт эдийн засгийн чөлөөт байдал (либерализм) ардчилал хүний эрхийг дээдлэх зэрэг

\*Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

олон ололтыг авчирсан. Гэвч нөгөөтэйгүүр нийгмийн тогтвортой байдал сөрөг талын олон үр дүнг авчирсныг ч гэсэн хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Энэхүү таамаглалынхаа хүрээнд аюулгүй байдал, үзэл суртал ба шашин шүтлэг, эдийн засаг, хүн ам, хүрээлэн буй орчны өөрчлөлт, эрчим хүч, технологи, өргөн оролцоо буюу олон талт хамтын ажиллагаа гэсэн үндсэн 8 чиглэлээр 10 жилийн дараах дэлхий ертөнцийн дүр зураг болон түүнд Британий оролцоо ямар байх талаар тодорхойлон гаргажээ.

Ирэх 10 жилийн хувьд улс төрийн хүрээнд улс гүрний дотоодын зөрчил мөргөлдөөнөөс зайлсхийж сэргийлэх явдал байх ажээ.

Өрнөдийн ардчилалд бусад улс гүрэн болон цэргийн холбоодын ердийн цэргийн дайралтаас үүдэх аюул бага байх болно. Харин үүний оронд үй олноор хөнөөх зэвсгийн хяналтгүй хэрэглээ болон дэлхийн бусад хэсэг дэх өрнөдийн эзэмшилд халдах террорист халдлага зэрэг нь илүү бодит аюул занал болж байгаа билээ. Терроризм болон хүн амын хэт өсөлт нь олон улсын хэмжээн дэх бусад гэмт үйлдэл тухайлбал мансууруулах бодис, хүний наймаа, бохир мөнгө угаах зэрэг гэмт хэргийн бусад хэлбэрүүдтэй шууд холбогдож байна. Олон тооны хөгжиж буй улс гүрнүүд нэн ялангуяа Африкийн орнууд дахь хүн амын өдөр тутмын амьдралын аюулгүй байдал ч мөн нэлээд ноцтой болох ажээ. Ундны ус болон бусад хүнсний зүйлсийн хомсдол, авилгал хээл хахууль, халдварт өвчний тархалт хийгээд улс төрийн хямрал зэрэг нь дотоод зөрчлийн томоохон шалтгаан болно. Эдгээр нь цаашлаад олон улсын хэмжээнд аюулгүй байдалд нөлөөлөх учраас эртнээс энэ бүхнийг олон талаас анхааран хамтран ажиллаж урьдчилан сэргийлэх шаардлага урган гарч байна.

Үзэл суртал ба шашин шүтлэгийн хувьд улс төрийн үзэл баримтлал нь өнгөрсөн XX зууны Европ болон дэлхийн бусад хөгжилтэй улс гүрэнд хор хөнөөл учруулахуйц, өөрөөр хэлбэл өмнөх түүхэн үе шиг 2 тал болон хуваагдах хүчин зүйл болохгүй. Өнөөдрийн бидний хэрэгжүүлж буй чөлөөт ардчилал болон зах зээлийн эдийн засгийн үзэл номлол нь нэлээд боловсронгуй болсон бөгөөд цаашдаа ч улам бүр хурдацтайгаар түгэн дэлгэрэх болно. Шашин шүтлэг болон соёлоос үүдсэн XXI зууны эхний үед Британи болон бусад шашнаас хараат бус ардчилалд сөргөлдөөн бий болох магадлал бий. Шашны шүтлэг бишрэл нь олон улсын харилцаанд өмнөхтэй адил өдөөгч хүчин зүйл болсоор байна. Зарим тохиолдолд энэ нь далд улс төрийн зорилгоор ашиглагдах магадлал ч байна. Асуудлын гол нь өрнөдийн ардчилагчид болон зарим исламын шашинт улс гүрэн, бүлгийн хоорондох итгэл үнэмшил хийгээд соёлын үнэт зүйлсийн ялгааны харилцаанаас үүдэн гарах бизээ.

Ирэх 10 жилийн хугацаанд болон цаашдаа Британи болон бусад өрнөдийн ардчилсан орнуудын хамгийн чухал стратеги зорилтын нэг нь

исламын шашинт улс гүрнүүд, мөн өөрсдийн нийгэм дэх эдгээр бүлгийн хүн амтай харилцах харилцаагаа нааштайгаар зохицуулах асуудал юм. Тиймээс тэдний шашин шүтлэг болон улс төрийн үзэл бодлын талаарх өөрсдийн ойлголтыг сайжруулах зайлшгүй шаардлагатай болно. Энэ үйл хэрэгт барууны улс гүрнүүдэд цагаачлан амьдарч буй муслим шашинт нийгмийн бүлэг голлох үүргийг гүйцэтгэх болно. Ингэснээрээ Арабын ертөнцийн улс орнуудын улс төр, нийгмийн төвшний шинэчлэлийг тайван замаар хийхэд тодорхой хувь нэмэр оруулах юм. Францын дунд сургуулиудад исламын уламжлалт эмэгтэй хүний унжлага хэрэглэхийг хориглосонтой холбоотой үүссэн зөрчил үүний нэгэн жишээ болж болох юм.

Эдийн засгийн салбарт АНУ нь дэлхий дахинд ноёрхсон үндэсний хүчирхэг эдийн засаг хэвээр байх бөгөөд Нэгдмэл Европын ДНБ-ний нийлбэр хэмжээ үүнд дөхөж очих боловч өсөлтийн хурд нь хараахан тэднийг гүйцэхгүй ажээ. Евро нь олон улсын хэмжээнд өөрийн статусыг тогтворжуулж улам илүү нэр хүндтэй мөнгөн дэвсгэрт болохын хэрээр Европын улс гүрнүүдийн эдийн засаг хоорондоо уялдаа холбоо, харилцан хамааралтай нэгэн цогц болох үйл явц үргэлжлэх юм. Дараагийн 10 жилд Япон нь дэлхийн хоёр дахь том үндэсний эдийн засаг болох бөгөөд Хятадын эдийн засгийн өсөлт нь Германыг гүйцэн түрүүлж гуравдахь том өрсөлдөгч болох ирээдүй байгаа юм. Эдгээр нь Номхон далайн эргийн дагуух хамгийн том 3 үндэсний эдийн засаг болох ажээ.

Олон улсын хувийн хөрөнгө болон худалдааны эргэлт нэмэгдэх боловч үнийн өсөлт удаан байна. Энэ нь хөдөлмөр ихээхэн шаардсан үйлдвэрүүд хөгжиж буй улсууд руу нүүхэд хүргэх ба Дэлхийн Худалдааны Байгууллага илүү олон талаар зохицуулалт хийж чадвал худалдааны саад тотгор улам бүр багасан арилах болно.

Даяаршсан эдийн засаг дахь тэгш бус байдлыг дагаад баян чинээлэг болоод ядуу буурай улс орны хоорондын улс төрийн түгшүүрт байдал ч улам бүр өсөн нэмэгдэх ажээ. Ядуурлыг бууруулахын төлөө тэмцэл, тогтвортой хөгжлийг дэмжих зэрэг хүчин чармайлтын үрээр зарим нэгэн талаар амжилтанд хүрч болох юм. Өндөр хөгжилтэй болон хөгжиж буй улсууд илүү ихийг амлаж, тусламж үзүүлэхгүй бол Мянганы хөгжлийн зорилт амжилт олох магадлал багатай юм.

Африк тивийн улс орнууд дахь хүн амын эрүүл мэнд, дундаж наслалт, аюулгүй байдал, төрийн бодлого болон хөгжлийн хувьд хамгийн эмзэг, бүрхэг цэг байсаар байна. Ирэх 10 жилийн дараа ч гэсэн энэ тив өөрийн бэрхшээл зовлон, бодит байдал зэргээсээ шалтгаалан богино хугацаанд их хэмжээгээр ядуурсан бүс нутаг хэвээр байх бөгөөд хэрэв ямар нэгэн байдлаар тодорхой арга хэмжээ авахгүй бол түүний дараа Ойрхи Дорнодын бүс нутаг орж болох юм.

Өмнөд болон Төв Африк дахь ДОЖ-ын нөлөөгөөр хуримтлагдсан сөрөг үр дагавар нэмэгдсэнээс шалтгаалан эдийн засаг, нийгэм нь үгүйрэн хоосрох бөгөөд уг өвчний тархац одоо ч гэсэн өндөр хурдацтай байгаа Ази, Дорнод Европын зарим хэсэг болон хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улс орнуудад ч гэсэн энэ хандлага хамаатай юм.

Улсын нэрс	ДНБ-ний есөлтийн төсөөлөл тэрбум ам.доллар	
	2003	2013
Европын 25	11.000	15.787
АНУ	10.869	18.696
Япон	4256	4.867
Герман	2331	2.841
Их Британи	1730	2.515
Франц	1689	2.384
Итали	1418	1.900
Хятад	1332	3.496
Испани	801	1.237
Мексик	613	943
Канад	814	1.414
Энэтхэг	533	1.135
Өмнөд Солонгос	507	1.102
Нидерланд	499	748
Австрали	480	826
Бразил	457	624
ОХУ	418	759

Өндөр хөгжилтэй улс орны хүн амын өсөлтийн тэнцэл нь тогтвортой байх боловч энэ нь нөгөө талаараа хүн амын дундаж хөгшрөлт, тооны бууралт цагаачлал, татвар төлөлт болон нийгмийн үйлчилгээний салбарт нөлөөлөх ажээ. Эдгээр хүндрэл бэрхшээл нь АНУ-д гэхээсээ илүүтэй Европын улсуудад мэдрэгдэх болно. Жишээлбэл Британий нийт хүн ам дахь 60-аас дээш насныхан эзлэх хувь 21 байгаа бол 2050 он гэхэд 30 хувьд хүрэх ажээ.

Хойд Африк, Ойрхи Дорнод, Латин Америк тэр дундаа Азийн хүн амд залуусын эзлэх хувийн өсөлтөөс шалтгаалан эдгээр улсууд өөрсдийн байгалийн нөөц баялаг болон нийгмийн тогтвортой байдлын талаар хүч анхаарал тавих шаардлага бий болно.

Хүн амын шилжилт хөдөлгөөн нь олон улсын хэмжээнд анхаарал татсан асуудал болон урган гарна. Аюулгүй байдал, хөгжил цэцэглэлтэд татагдсан эдийн засгийн холбогдолтой цагаачдын нүсэр цуваа Европ, Хойд Америк руу тэмүүлэх болно. Хэдийгээр эдгээр бүс нутагт эдийн засгийн хувьд ашигтай идэвхтэй хүмүүс хэрэгтэй байх боловч захиргааны шахалтын үр дүнд “хойш чиглэсэн нүүдэл” тодорхой хэмжээнд барьж болох юм.

Хөгжиж буй улсуудын дотоодод болон хоорондын хүн амын шилжилт хөдөлгөөн маш их жишээ нь Ази тив дэх тогтвортой бус хөгжилтэй улсууд үүний нэг илрэл болох ажээ.

Улс	Хүн амын тоо ба өсөлт (сая)		
	2003 он	2015 он	2050 он
Европын 25	454	457	432
АНУ	294	330	409
Япон	128	127	110
Герман	82	82	79
Британи	59	61	66
Франц	60	63	64
Итали	57	56	45
Хятад	1304	1402	1395
Испани	41	41	37
Канад	32	34	39
Мексик	103	120	140
Энэтхэг	1065	1246	1531
Өмнөд Солонгос	48	50	46
Нидерланд	16	17	17
Австрали	20	22	26
Бразил	178	202	233
Орос	143	133	101

Энэ хүснэгтээс зарим нэгэн сонирхолтой таамаглалыг олж харж болох юм. Жишээ нь, ихэнх хөгжингүй улс орны хүн амын өсөлт зогсонги буюу буурах хандлагатай байгаа бол хөгжиж буй улсуудынх өсөх магадлалтай. Мөн түүнчлэн хүн амын тоогоороо тэргүүлэгч Хятад, Энэтхэг улсууд энэхүү байр сууриа цаашид ч хадгалсаар байх боловч хүн амын өсөлтийг хянах хатуу бодлогынхоо ачаар Хятад улс тодорхой хэмжээнд барьж чадах бол Энэтхэг нь Хятадыг энэ үзүүлэлтээрээ гүйцэн түрүүлэх ажээ.

Хүрээлэн буй орчны өөрчлөлтийн хувьд глобал шинж чанар бүхий нэлээд өөрчлөлт гарах юм. Ирэх 10 жилийн дотор цаг агаарын өөрчлөлт тэр дундаа дулааралт болон үүнээс улбаалсан далайн усны төвшний ихээхэн өөрчлөлт гарах ажээ. Үер ус, зуд турхан, халуун бүсийн тариалангийн талбай дахь хуурайшил, малиар болон ундны уснаас шалтгаалах өвчний тархалт зэрэг гамшгаас шалтгаалан дэлхийн биологийн төрөл зүйл болоод нийгэм, эдийн засаг ихээхэн хохирол, сүйрэл хүлээх болно. Тогтвортой хөгжлийн цохилт нь Африк, Ази болон Латин Америкийн эмзэг бүсэд илүү хүчтэй нөлөөлөх болно. Биологийн төрөл зүйлийн уналт доройтол нь алдагдлын хэмжээг удаашруулах талаар тавьж буй олон улсын хамтын ажиллагааны үйл явцаас үл хамааран үргэлжилсээр байх ажээ.

Дэлхий даяар эрчим хүчний эрэлт хэрэгцээ маш ихээр өсөх бөгөөд голчлон эдийн засгийн өндөр хөгжилтэй улсууд ялангуяа Зүүн Азиас бусад бүс нутагт улам хүнд тусах болно. Одоогоор олноод байгаа газрын тосны нөөц баялаг нь глобал хэрэгцээг хангахад ойрын ирэдүйдээ хангалттай хэдий ч шинээр газрын тос, байгалийн хийн нөөц

илрүүлэх нь нэн чухал юм. Персийн булан нь газрын тос олборлох голлох бүс нутаг хэвээр байх ажээ. Олон улсын эрчим хүчний дэд бүтэц дэх хараат байдал өсөхийн хэрээр энэ салбар нь олон улсын харилцаан дахь чухал салбар болно.

Технологийн ололт амжилт нь өөрчлөлтийн гол хөдөлгөгч хүчин болно. Өсөн нэмэгдэж буй хөгжил цэцэглэлт ба даяаршил, мэдээлэл солилцох өргөн бололцоо зэрэг нь өнөөдөр нүүрлээд буй халдварт өвчин, хоол ундны хомсдол болон хүрээлэн буй орчны өөрчлөлт зэрэг асуудлыг зарим талаар шийдэх бололцоотой юм. Нөгөөтэйгүүр технологийн дэвшил нь гэмт хэрэг, эдийн засгийн тэнцвэрт бус байдалд дөхөм үзүүлэх сөрөг тал авчрахыг ч тооцоолж үзэх хэрэгтэй юм.

Хэдхэн жилийн өмнө төсөөлөөгүй байсан үүрэн телефон, интернэт, цахим шуудан зэрэг нь олон улсын харилцааг хөтлөн явах, өндөр түвшинд хэдүйн хүрснээр өнөөгийн техник, технологийн дэвшил дэлхийн ирээдүйд гүйцэтгэх үүргийг тодорхойлж байгаа билээ.

Зарим тохиолдолд биотехнологи зэрэг шинжлэх ухааны зөрчилтэй ололт амжилт нь дүн шижилгээ хийх болон хяналт тавих олон улсын шинэ механизмыг шаардаж болох юм.

Шинэ технологи, даяаршил болон бидний нийгмийн нээлтэй байдал нь олон улсын харилцаан дахь тал бүрийн олон талт оролцооны нэгэн үр дүн юм. Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл нь олон нийтийн оролцоо ба захиргаанд шахалт үзүүлэх зэргээрээ томоохон хөдөлгөгч хүч байсаар байх болно. Бизнес болон төрийн бус байгууллагуудын үүрэг хариуцлага нь ирээдүйд улам илүү чухал өргөн хүрээг хамарсаар байх ажээ. Тэд төр засгийг хариуцлагаа улам илүү хүчтэй ухамсарлахад тус дөхөм болохын зэрэгцээ төр засгаас хүрээлэн буй орчин, ядуурал зэрэг глобал шинжтэй асуудлыг зохицуулахад шахалт үзүүлэх болно. Бүс нутаг, үүрэг шилжүүлсэн захиргаа (Devolved Administration) зэрэг төрийн төвшнөөс арай доогуурх хүрээний олон улсын харилцаа нь цаашдаа улам бүр чухал шаардлагатай болох ажээ. Энэ тохиолдолд дипломат албаны ажилтнууд нь олон нийттэй харилцах болон харилцаа холбоондоо улам чадварлаг болох нь чухал юм.

Англи хэлийг дэлхий дахинд нийгмийн бүхий л салбарт улам бүр өргөн хэрэглэх бөгөөд боловсрол, соёл урлаг зэрэг нь Британи зэрэг өрнийн улс орны нөлөөг түгээн дэлгэрүүлэх чухал хэрэгсэл байх байр сууриа хадгалах болно.

Эдгээр таамаглалууд нь зөвхөн уг байгууллагын судлаачдын гаргасан тойм төдий төсөөллүүд бөгөөд ямар нэгэн байдлаар албан ёсны судалгаа, тоо баримт биш болохыг болгооно уу. Хэрэв уг материалтай танилцахыг хүсвэл <http://www.fco.gov.uk> web хуудаснаас үзнэ үү.